



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 06 өдөр

Дугаар A/559

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "А" заалт үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн сурагчдын сүүний өдөр-2019 арга хэмжээг зохион байгуулж, тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч Д.Нарандорж -Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дэд дарга

Гишүүд: Д.Гантогоо -Жаргалант сумын 3 дугаар сургуулийн Захирал

Т.Буянтогтох -Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр, газар тариалангийн албаны дарга

Н.Батцагаан -НҮБ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн зохицуулагч

Д.Ариунбилэг -Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Р.Алимаа - Жаргалант сумын 3 дугаар сургуулийн сургалтын менежер

2. Дэлхийн сурагчдын сүүний өдөр-2019 арга хэмжээг удирдлага арга зүйгээр ханган чанартай зохион байгуулж, жил бүр уламжлал болгож хэвшүүлэх арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Нарандорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ



D/Zax-A/559-Da

02 02759